



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/620

Улаанбаатар хот

Дотоод аудитын хороог шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын "Дотоод аудитын дүрэм" батлах тухай 2015 оны 483 дугаар тогтоол, Сангийн сайдын "Дотоод аудитын хорооны дүрэм" батлах тухай 2019 оны 29 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн байгуулсугай.

2. Дотоод аудитын хорооны нарийн бичгийн даргаар тус албаны ахлах аудиторыг томилж, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалын 5 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг даалгасугай.

3. Дотоод аудитын хороог мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Дотоод аудитын алба (Д.Төмөрбаатар)-д үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2021 оны А/335 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (А.Бямба)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.БАТТӨР

902310756
9091304 5 06723271

19/10/25
1825011710

27

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн
А/620 дугаар захирамжийн хавсралт

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга:

Дүүргийн Засаг даргын орлогч

Хорооны гишүүд:

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх
зүйн хэлтсийн дарга

Дүүргийн Дотоод Аудитын албаны дарга

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-
шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн
тасгийн дарга